



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ТӨСВИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараах хаягаар  
харилцана уу:**

САГ-ын дарга: С.Энхзаяа  
Утас: 261663  
Цахим хаяг:  
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер:  
Л.Одгэрэл  
Утас: 260512  
Цахим хаяг:  
odgerell@audit.gov.mn

Аудитор: Ж.Бямбацогт  
Утас: 261628  
Цахим хаяг:  
byambatsogtj@audit.gov.mn

Монгол Улсын  
Үндэсний Аудитын Газар  
Улаанбаатар  
Бага тойруу  
Засгийн газрын IY байр  
Цахим хуудас: www.audit.mn

### АГУУЛГА

Оршил  
Санхүүгийн дотоод хяналт  
Илрүүлсэн гол зүйлс,  
гаргасан шийдлүүд  
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт  
Аудитын санал дүгнэлт

**Хавсралт 1:** Аудитын гэрчилгээ

**Хавсралт 2:** Менежментийн захидал

**Хавсралт 3:** Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн  
тайлан

## Оршил

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын төсвийн багцын 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг төслийн удирдлагад танилцуулж байна.

Менежментийн захидалд санхүүгийн хяналтын журмыг сайжруулах талаарх бидний зөвлөмжүүд болон манай зөвлөмжийн талаар тус төслийн ирүүлсэн хариуг тусгасан болно.

Аудитын явцад мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансны нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзлээ.

### Санхүүгийн дотоод хяналтыг дахин хянах

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Ийнхүү дахин хянахдаа Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн даргын хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон. Тухайн жилд асуудал үүсгэсэн эдгээр хяналтыг бид Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын удирдлагад танилцуулж байна.

Бусад чиглэлээр хяналтыг сайжруулж болох бөгөөд энэ талаар Удирдлагын захидалд өгүүлсэн болно.

Дараах түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд байгууллагын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

- Хэлмэгдэж байсан онуудад хувь хүний нэр дээр орон сууц эзэмшүүлсэн тухай ямар нэгэн нотлох баримт олгогдож байгаагүй байна. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 23.1 “Улс төрийн хилс хэрэгт шүүх болон түүнийг орлосон байгууллагын шийдвэрээр эрүүгийн ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгч, нас барсан хэлмэгдэгчийн эхнэр /нөхөр/ хэлмэгдүүлэлтийн улмаас гэр, орон сууц хөлслөх гэрээний үндсэн дээр эзэмшиж байсан орон сууцаа хураалгуулж одоо хүртэл орон сууцгүй байгаа бол байнга оршин суугаа аймаг, нийслэлийн Засаг дарга дараалал харгалзахгүйгээр орон сууц, гэр олгоно” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлэхээр эрх зүйн зохицуулалт хийж өгөөгүйгээс 2013 онд хэлмэгдэн орон сууцаа хураалгасан гэсэн нотлох баримтгүйгээр хэлмэгдэгсдэд орон сууцны мөнгөн олговор 210.0 сая төгрөг олгосон байна.

### **Аудитаар илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд**

- Тайлант онд санхүүгийн програмаар НББ-ийг хөтлөхдөө өглөг, авлага, бараа материалын журналаар дамжуулж гүйлгээ хийхгүйгээр авлага 20.3 сая төгрөг, бараа материал 7.2 сая төгрөг, биет бус хөрөнгийн 3.0 сая төгрөг, нийт 30.4 сая төгрөгийг шууд зардалд бичиж тайлант оны үр дүнг бууруулсныг аудитын явцад залруулав.
- Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс болон Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн Судалгааны төв нь 162.1 сая төгрөгийн цалин, 19.9 сая төгрөгийн НДШ-ийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичилт хийж Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг мөрдөж ажиллаагүй байна.

### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

“НББ-ийн тухай хуулийн 8.3-д заасны дагуу ажил гүйлгээг үнэн зөв, иж бүрэн илэрхийлж, НББ-ийн хураангуй дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж байх” гэсэн 1 зөвлөмж өгөгдөж бараа материалын нэр төрөл, үнийн дүнгээр нягтлан бодох бүртгэлийн хураангуй, дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж байгаа болно гэсэн хариу ирүүлсэн боловч дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөөгүй байна.

### **Аудитын санал дүгнэлт**

Бид Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын 2013 оны санхүүгийн тайланд **“Зөрчилгүй”** санал дүгнэлт өгөхийг Монгол улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.09.25 № 683  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН  
КОМИССЫН ДАРГА Л.ЦОГ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15.1, Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

  
А.ЗАНГАД

**ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН  
КОМИСС**

**2013 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН**

**Менежментийн захидал**

**Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс**

**Асуудал 1** Нягтлан бодох бүртгэлийн  
талаар

## **Менежментийн захидал**

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг хэрхэн сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан юм.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

**ҮАГ-ын ажиглалт**

Тайлант онд санхүүгийн програмаар өглөг, авлага, бараа материалын журналаар дамжуулж гүйлгээ хийхгүйгээр авлага 20.3 сая төгрөг, бараа материал 7.2 сая төгрөг, биет бус хөрөнгийн 3.0 сая төгрөг, нийт 30.4 сая төгрөгийг зардалд бичиж тайлант оны үр дүнг бууруулсан байна.

**ҮАГ-ын зөвлөмжүүд**

Мөнгөн хөрөнгөнөөс гүйлгээг хийхдээ тооцооны дансаар дамжуулж хийж байх;

**Эрсдэлүүд**

Тайлант үеийн зардлыг нэмэгдүүлэх, НББ-ийг зохих ёсоор хийгээгүйгээс төсвийн хөрөнгө үнэгүйдэж, шамшигдал, ашиглан үүсч улмаар бараа материалын зарцуулалтанд тавих хяналт алдагдаж, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

**Үйлчлүүлэгчийн хариу**

2014 оны 7 дугаар сарын 15-ны дотор зөвлөмжийг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллана.

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант үе: 2013.01.01-2013.12.31

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
<b><u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</u></b>	<b>1,030,000.80</b>	-
Кассад байгаа бэлэн мөнгө	1,000,000.00	-
Жижиг мөнгөн сан		-
Банкинд байгаа бэлэн мөнгө	30,000.80	-
<b><u>АВЛАГА</u></b>	<b>12,607.00</b>	<b>20,253,000.00</b>
Байгууллагаас авах авлага	12,607.00	13,253,000.00
Бусад авлага		<b>7,000,000.00</b>
<b><u>УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР</u></b>		-
Урьдчилж гарсан зардал		-
<b><u>БАРАА МАТЕРИАЛ</u></b>	<b>371,650.00</b>	<b>12,090,308.00</b>
Бэлэн бүтээгдэхүүн		-
Эм боох		-
Бичиг хэргийн материал	371,650.00	<b>12,090,308.00</b>
Аж ахуйн материал		-
Сэлбэг хэрэгсэл		-
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,414,257.80</b>	<b>32,343,308.00</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		-
<b><u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u></b>	<b><u>39,872,323.00</u></b>	<b>46,897,177.00</b>
Барилга, байгууламж		-
Хуримтлагдсан элэгдэл		-
Авто- тээврийн хэрэгсэл		-
Хуримтлагдсан элэгдэл		-
Машин, тоног төхөөрөмж	26,403,201.00	<b>38,326,001.00</b>
Хуримтлагдсан элэгдэл	(5,527,883.00)	<b>(14,193,712.00)</b>
Тавилга, аж ахуйн эд хогшил	20,126,489.00	<b>26,350,289.00</b>
Хуримтлагдсан элэгдэл	(6,736,128.00)	<b>(9,192,045.00)</b>
Номын фонд	5,606,644.00	<b>5,606,644.00</b>
Дуусаагүй барилга, байгууламж		-
Биет бус хөрөнгө	-	-
Программ хангамж	1,155,000.00	<b>1,155,000.00</b>
Хуримтлагдсан элэгдэл	(1,155,000.00)	<b>(1,155,000.00)</b>
Бусад		<b>3,000,000.00</b>
Хуримтлагдсан элэгдэл		-
<b><u>БУСАД ХӨРӨНГӨ</u></b>		-
		-
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>39,872,323.00</b>	<b>49,897,177.00</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>41,286,580.80</b>	<b>82,240,485.00</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		-
<b>Өглөг</b>	-	-
Ажиллагчидтай холбогдсон өглөг		-
Бусад өглөг		-
<b>Урьдчилж орсон орлого</b>		-
Урьдчилгаа- Төсвийн татаас		-
Бусад урьдчилж орсон орлого		-
<b><u>БОГИНО ХУГАЦААТ ӨР</u></b>		-
<b><u>ТӨЛБӨРИЙН ДҮН</u></b>		-
Урт хугацаат зээл		-
<b><u>УРТ ХУГАЦААТ ӨР,</u></b>		-
<b><u>ТӨЛБӨРИЙН ДҮН</u></b>	-	-
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	-	-
Засгийн газрын хувь оролцоо	75,918,503.00	<b>75,918,503.00</b>
Хуримтлагдсан үр дүн	(35,463,692.20)	<b>5,490,212.00</b>
Өмнөх үеийн үр дүн	(35,463,692.20)	<b>(35,463,692.20)</b>



Тайлант үеийн үр дүн		<b>40,953,904.20</b>
Дахин үнэлгээний нэмэгдэл	831,770.00	<b>831,770.00</b>
		-
<b><u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</u></b>	<b>41,286,580.80</b>	<b>82,240,485.00</b>
<b><u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</u></b>	<b>41,286,580.80</b>	<b>82,240,485.00</b>

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант үе: 2013.01.01-2013.12.31

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>		
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>875,332,806.60</b>	<b>879,324,360.00</b>
Улсын төсвөөс	842,343,585.60	863,325,760.00
Төсөл арга хэмжээ		0.00
Хөрөнгийн	32,989,221.00	15,998,600.00
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>0.00</b>	<b>25,897,700.00</b>
Өмчийн орлого		
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		25,897,700.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>		
	<b>178,363,308.00</b>	<b>201,143,634.35</b>
Цалин	161,101,439.00	181,245,479.80
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	17,261,869.00	19,898,154.55
Эрүүл мэндийн даатгалын хураамж		0.00
<b>Тогтмол зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Хоол		0.00
эм		0.00
<b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>	<b>658,982,568.60</b>	<b>663,124,521.45</b>
Бичиг хэргийн материал	4,044,329.00	1,514,950.00
Тээвэр, шатахууны зардал	16,417,396.60	15,875,587.00
Шуудан холбооны зардал	2,563,508.00	2,989,049.80
Дотоод томилолтын зардал	9,502,120.00	5,795,625.00
Гадаад томилолтын зардал	13,356,775.00	15,020,426.00
Ном, хэвлэлийн зардал / бичиг хэргийн	20,504,195.00	7,754,484.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	703,520.00	388,800.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	37,889,741.00	29,304,461.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал		0.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд	1,689,527.00	2,452,024.00
Урсгал засвар	410,799.00	730,700.00
Гадаадын зочны зардал	295,063.00	0.00
Бусад зардал		0.00
Тээврийн хэрэгслийн даатгал, оношлогоо		0.00
Байрны түрээс	10,904,800.00	11,647,120.00
Програм хангамж		0.00
Аж ахуйн материал худалдан авах зардал		20,904,060.00
Сонгуулийн зардал		0.00
Холбооны суваг ашигласан		0.00
Элэгдлийн зардал	5,392,578.00	11,121,747.00
<b>Хөтөлбөр арга хэмжээний зардал</b>		<b>0.00</b>
Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах зардал	16,500,000.00	16,458,600.25
Хэлмэгдэгсэд, тэдний ар гэрт олгох нөхөн олговор	117,771,000.00	82,578,954.75
Төвлөрүүлэх шилжүүлэг	3,467,476.00	37,657,932.65
Ахмад дайчдад үзүүлэх орон сууцны хөнгөлөлт нэг удаагийн тэтгэмж	358,000,000.00	400,000,000.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	840,000.00	930,000.00
	38,729,741.00	0.00
		0.00
		0.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>837,345,876.60</b>	<b>864,268,155.80</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>37,986,930.00</b>	<b>40,953,904.20</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (бодит)		0.00
Үндсэн хөрөнгө худалдсаны олз		0.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>		<b>0.00</b>

<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>		0.00
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (бодит)		0.00
Хөрөнгө худалдсаны гарз		0.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>37,986,930.00</b>	<b>40,953,904.20</b>

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант үе: 2013.01.01-2013.12.31

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	АУДИТЛАГДСАН
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>		
<b><u>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u></b>	<b>875,332,806.60</b>	<b>879,324,360.00</b>
Улсын төсвөөс	842,343,585.60	863,325,760.00
Төсвийн хуваарилаагүй зардал		0.00
Засгийн газрын нөөц		0.00
Төсөл арга хэмжээ		0.00
Хөрөнгийн	32,989,221.00	15,998,600.00
Бусад байгууллагаас		0.00
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Өмчийн орлого		0.00
Үндсэн үйл ажиллагааны орлого		0.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		0.00
Хүүгийн орлого		0.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>875,332,806.60</b>	<b>879,324,360.00</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>		
	<b>178,375,915.00</b>	<b>201,131,028.35</b>
Цалин	161,101,439.00	181,245,479.80
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	17,274,476.00	19,885,548.55
Эрүүл мэндийн даатгалын хураамж		0.00
<b>Тогтмол зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Гэрэл цахилгааны зардал		0.00
Түлш, халаалтын зардал		0.00
Цэвэр, бохир усны зардал		0.00
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Хоол		0.00
эм		0.00
<b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>	<b>652,864,632.40</b>	<b>658,076,732.45</b>
Бичиг хэргийн материал	3,568,870.00	1,554,200.00
Тээвэр, шатахууны зардал	16,417,396.60	15,875,587.00
Шуудан холбооны зардал	2,563,508.00	2,989,049.80
Дотоод томилолтын зардал	9,502,120.00	5,795,625.00
Гадаад томилолтын зардал	13,356,775.00	15,020,426.00
Ном, хэвлэлийн зардал / бичиг хэргийн	20,254,295.00	24,283,332.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	703,520.00	388,800.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	37,889,741.00	36,304,461.00
Мэргэжил дээшлүүлэх		0.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал		0.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал		0.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд	1,689,527.00	2,452,024.00
Урсгал засвар	410,799.00	730,700.00
Харуул хамгаалалт		0.00
Техникийн нөхцөл, улаан шугам тавиулсан зардал		0.00
Гадаадын зочны зардал	295,063.00	0.00
Аж ахуйн материал худалдан авах зардал		3,409,920.00
Тээврийн хэрэгслийн даатгал, оношлогоо		0.00
Байрны түрээс	10,904,800.00	11,647,120.00
Програм хангамж		0.00
Газрын төлбөр		0.00
Сонгуулийн зардал		0.00
Холбооны суваг ашигласан		0.00
		0.00
<u>Хөтөлбөр арга хэмжээний зардал</u>		0.00
<u>Засгийн газрын нөөц сан</u>		0.00

Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах зардал	16,500,000.00	16,458,600.25
Хэлмэгдэгсэд, тэдний ар гэрт олгох нөхөн олговор	117,771,000.80	82,578,954.75
Төвлөрүүлэх шилжүүлэг	3,467,476.00	37,657,932.65
Ахмад дайчдад үзүүлэх орон сууцны хөнгөлөлт	358,000,000.00	400,000,000.00
нэг удаагийн тэтгэмж	840,000.00	930,000.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	38,729,741.00	0.00
		0.00
		0.00
		0.00
		0.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	<b>831,240,547.40</b>	<b>859,207,760.80</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>44,092,259.20</b>	<b>20,116,599.20</b>
<b>Хөрөнгийн орлого</b>		0.00
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		0.00
Бусад хөрөнгийн борлуулалтын орлого		0.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>		0.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал		21,146,600.00
Хөрөнгийн бусад зардал		0.00
гарсан зардлаа дансны нэгдсэн жагсаалтаас авах		0.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)</b>	-	<b>21,146,600.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨН/ ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)</b>	-	<b>(21,146,600.00)</b>
<b>САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		0.00
Авсан зээл		0.00
Төлсөн зээл		-
<b>САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨН/ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)</b>	<b>44,092,259.20</b>	<b>(1,030,000.80)</b>
<b>Валютийн ханшийн зөрүү</b>		
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)</b>	<b>44,092,259.20</b>	<b>(1,030,000.80)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,030,000.80
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	44,092,259.20	(0.00)

## АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант үе: 2013.01.01-2013.12.31

*/төгрөгөөр/*

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН
2012 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	-			-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Залруулсан үлдэгдэл</b>				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн	-			
2012 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	75,918,503.00	831,770.00	(35,463,692.20)	41,286,580.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
<b>Залруулсан үлдэгдэл</b>			-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн	-	-	40,953,904.20	40,953,904.20
				-
2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	75,918,503.00	831,770.00	5,490,212.00	82,240,485.00

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант үе: 2013.01.01-2013.12.31

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨСӨВ	ТАЙЛАНТ ОН	ЗӨРҮҮ	ХУВЬ
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	913,216,300.00	842,696,428.15	70,519,871.85	92.3
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	913,216,300.00	842,696,428.15	70,519,871.85	92.3
<b>IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>897,217,700.00</b>	<b>826,697,828.15</b>	<b>70,519,871.85</b>	<b>92.1</b>
Бараа, үйлчилгээний зардал	395,487,700.00	343,188,873.40	52,298,826.60	86.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,592,900.00	181,245,479.80	14,347,420.20	92.7
үндсэн цалин	175,134,900.00	162,103,236.80	13,031,663.20	92.6
Гэрээт ажилчдын цалин	10,708,400.00	10,946,876.00	(238,476.00)	102.2
Унаа хоолны хөнгөлөлт	9,749,600.00	8,195,367.00	1,554,233.00	84.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,869,600.00	19,885,548.55	1,984,051.45	90.9
Тэтгэврийн даатгал	21,869,600.00	19,885,548.55	1,984,051.45	90.9
Бараа, үйлчилгээний бусад зардал	178,025,200.00	142,057,845.05	35,967,354.95	79.8
Бичиг хэрэг	6,387,000.00	1,554,200.00	4,832,800.00	24.3
Тээвэр (шатахуун)	22,700,000.00	15,875,587.00	6,824,413.00	69.9
Шуудан  холбоо	5,047,400.00	2,989,049.80	2,058,350.20	59.2
Дотоод албан томилолт	9,029,600.00	5,795,625.00	3,233,975.00	64.2
Гадаад томилолт /арга хэмжээ/	12,338,000.00	15,020,426.00	(2,682,426.00)	121.7
Ном хэвлэл авах	39,230,000.00	24,283,332.00	14,946,668.00	61.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	773,200.00	388,800.00	384,400.00	50.3
Урсгал засвар	922,800.00	730,700.00	192,100.00	79.2
Төлбөр хураамж болон бусад зардал	7,512,200.00	5,861,944.00	1,650,256.00	78.0
Гадаад зочны зардал	800,000.00	-	800,000.00	-
Байрны түрээсийн зардал	14,163,000.00	11,647,120.00	2,515,880.00	82.2
Түүх соёлын дурсгалт зүйл хамгаалах зардал	16,500,000.00	16,458,600.25	41,399.75	99.7
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	42,622,000.00	41,452,461.00	1,169,539.00	97.3
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	42,622,000.00	41,452,461.00	1,169,539.00	97.3
Татаас ба урсгал шилжүүлэг	501,730,000.00	483,508,954.75	18,221,045.25	96.4
өрх гэрт олгох шилжүүлэг	501,730,000.00	483,508,954.75	18,221,045.25	96.4
Нийгмийн халамжийн зардал	400,000,000.00	400,000,000.00	-	100.0
Ахмад дайчдад олгох нэг удаагийн тусламж	400,000,000.00	400,000,000.00	-	100.0
Хэлмэгдэгсэд, тэдний ар гэрт олгох тэтгэмж	100,900,000.00	82,578,954.75	18,321,045.25	81.8
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	830,000.00	930,000.00	(100,000.00)	112.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,998,600.00	15,998,600.00	-	100.0
Дотоод хөрөнгө оруулалт	15,998,600.00	15,998,600.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	897,217,700.00	841,666,427.35	55,551,272.65	93.8
Төсвөөс санхүүжих	897,217,700.00	841,666,427.35	55,551,272.65	93.8
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,030,000.80	(1,030,000.80)	